

ЗАН СУРТАХУУН, ЁС СУРТАХУУН ХЭМЭЭХ ОЙЛГОЛТУУДЫН УЧИР

М.Золзаяа

Хэл иргэншлийн дээд сургууль

Түлхүүр үг: ёс суртахуун, зан суртахуун, ёс зүй, ёс, суртал

Энэ өгүүлэлд ёс суртахуун, зан суртахуун гэх ойлголтуудын гарал үүсэл, утга, агуулга, хэрэглээ, судлаачдын тодорхойлолт, тайлбаруудыг нэгтгэн үзлээ.

I

Нийтийн ярианы хэлэнд төдийгүй судалгааны бүтээлүүдэд ёс зүй, зан суртахуун, ёс суртахуун гэдэг ойлголтыг харилцан орлуулж эсвэл ялгаатайгаар хэрэглэдэг. Дэлхийн ямар ч хэлэнд утга ижил, бичлэг өөр үгс олон байдаг. Оросын философич А.А.Гусейнов, Р.Г.Апресян нар¹, 2001 онд Оросын ШУА-ийн философийн хүрээлэнгээс хэвлүүлсэн ёс зүйн тайлбар тольд баримталснаар², мөн манайд доктор Д.Дашжамц³, Б.Дагзмаа⁴, З.Бат-Отгон⁵ нар “ёс суртахуун” ба “зан суртахуун” хэмээх нэр томъёог ижил утгаар хэрэглэсэн байна. Доктор А.Цэрэннадмид⁶ зан суртахуун гэдэг нэр томъёог онцолж үзээд “сайхан зан аашны хүчинд нийгэм төвширдөг. Энд төвшин зан, нэг ааш, намуун зөөлөн, найрсаг эелдэг, үнэнч шударга, нөхөрсөг гэх мэт эрхэмсэг зан авир эвийн цавуу нь болдог” гэж өгүүлжээ. Тухайлбал, доктор Д.Тунгалаг “Ёс суртахуун хоёр үндсэн хэлбэртэй. Үүнд, нэгдүгээрт, хувь хүний мөн чанарыг илэрхийлдэг ёс суртахууны чанарууд /эр зориг, шударга ёс, өгөөмөр сэтгэл, даруу зан г.м/ хоёрдугаарт, нийгмийн зан суртахууны хэм хэмжээ /хулгай бүү хий, амьтан бүү ал/ ба ойлголтын үнэлэмж /сайн, муу, үнэнч шударга чанар г.м/. Хувь хүний ёс суртахууны шинж нь түүний зан суртахууны чанараар илэрдэг бөгөөд зан суртахууны хэм хэмжээ нь хувь хүмүүсийн хоорондын харилцааны агуулга болдог. Энэ харилцаа нь нэг тохиолдолд субъектив хэлбэрээр илэрч байхад нөгөө тохиолдолд объектив харилцаагаар илэрдэг⁷” гэж бичжээ. Миний бие 2005 онд хэвлүүлсэн сурах бичигтээ эдгээр ойлголтуудыг ялгаатай гэж тайлбарлаж ирсэн уламжлалыг тэмдэглэхийн зэрэгцээ тэдгээрийг ижил утгаар авч үзсэн. Гэхдээ хоёрхон тайлбар

¹ А.А.Гусейнова, Р.Г.Апресян. Этика. М.,1998. с.10

² Этика. Энциклопедический словарь. М.,2001

³ Монголын философийн түүх /XVII-XIX/. УБ.,2001. 414, 417, 458 дахь тал.

⁴ Философи эхлэн сурах бичиг. УБ.,2000. 240 дэх тал.

⁵ З.Бат-Отгон. Ёс зүйн үндэс. УБ.,1997.

⁶ А.Цэрэннадмид. Хүн ёс, хүн төрх, зан суртахуун. УБ.,2002.

⁷ Д.Тунгалаг. Ёс зүй. УБ.,2002. 8 дахь тал.

толь ашиглаад тод нухацтай хандаж чадаагүйгээ энэ өгүүллээр нөхөх зорилготой бичиж байна.

Ёс зүйн түүхэнд сэтгэгчид ёс суртахуун, зан суртахуун гэдэг ойлголтыг хэрхэн тайлбарласныг авч үзье. Ёс зүйн түүхэнд Германы философич Г.В.Ф.Гегель ёс суртахуун, зан суртахуун хэмээх хоёр ойлголтыг ялган тайлбарласан. Товчхон хэлбэл хүний тодорхой үйлдлийн субъектив талыг ёс суртахуун гээд объектив талыг нь зан суртахуун гэж үзсэн. Оюун санааны хөгжил нь хийсвэр эрх, ёс суртахуун, зан суртахуун гэсэн гурван үе шатыг дамжин өнгөрөөдөг. Хийсвэр эрх субъектив байхад зан суртахуун объектив. Энэ хоёрын нэгдэл нь буюу төгс чанар нь эрх чөлөөний дээд шат болох ёс суртахуунд илрэлээ олдог гэж Г.В.Ф.Гегель үзжээ. Чөлөөт байдал гэдэг бол эрхэд илэрдэг хийсвэр ойлголт гэж тайлбарладаг. Иймээс эрх бол чөлөөт байдлын ахуй мөн. Түүнийхээр чөлөөтэй байна гэдэг бол хүн хийж байгаа зүйлийнхээ хязгаар хийгээд зайлшгүй чанарыг ухамсарлахыг хэлнэ. “Хэрвээ би ухаалаг зүйлийг хүсвэл тусгаарлагдсан хүн шиг бус, харин зан суртахууны байдалд зохицуулж авирлах болно. Ёс суртахууны үйлдэлд өөрийгөө биш, мөн чанарыг гол болгоно. Ёс суртахуунтай хүн өөрийн үйл ажиллагааг ухамсарладаг. **Ёс суртахуун** хүсэл зоригийн хэмжээнд байдаг. Хүсэл зоригийн илэрхийлэл нь ёс суртахууны ба субъектив үйлдэл байдаг. Өөрийнхөө зорилгыг биелүүлнэ гэдэг бол субъектив чанараа хадгалж байна гэсэн үг. Иймээс ёс суртахууны салбарт хүчирхийлэл байж болохгүй. Ийнхүү Г.В.Ф.Гегель ёс суртахууныг зөвхөн ухамсрын хэлбэр төдийгүй хүмүүсийн тодорхой харилцаа болохынх нь хувьд авч үзсэн. Өөрөөр хэлбэл ёс суртахуун нь хүмүүсийн олон талт харилцаатай холбоотой. Энэ утгаараа ёс суртахуун нь объектив үндэстэй. Зан суртахуунт чанар буян эрх чөлөөний үзэл, объектив оюун санааны хөгжлийн дээд үе шат юм. **Зан суртахууны хүрээнд** субъектийн юу хиймээр төлөвлөж байгаагаа ухамсарлах мэдлэг, хүсэл зориг байдаг. Зан суртахуунт чанар оюун ухаанд үндэслэсэн тодорхой үзэл санааны систем.¹ Зан суртахуунт иргэний нийгэмд тэгш бус байдал, ангиудын хуваагдал үүсч бий болохыг үгүйсгээгүй. Харин ч ердийн зүйл гэж үзэж байв. Энэ лүгээ адил хэл соёлын уламжлалд зан суртахуун гэдэг нь уламжилж ирсэн хамгийн эрхэм дээд зарчмууд, харин ёс суртахуун **зан байдлын** түүхэн хувьсамтгай хэм хэмжээг ойлгох явдал байжээ.² Нэр томъёог гарал үүслээр нь эх хэлний буюу зээлдсэн гэж ангилдаг.³ Г.В.Ф.Гегель герман хэлний “sittlichkeit”-ийг зан суртахуун /нравственность/, латин хэлний “**moralis**”-ыг зээлдэн ёс суртахуун гэж үзсэн. Германы Sitte-ёс гэсэн үгнээс sittlich-ёсны гэсэн хавсрал нэр үүсдэг. Үүнээс үзвэл мораль, нравственность, sittlichkeit гэдэг үгс нэг л ойлголт аж.

¹ Г.В.Ф.Гегель. Философия права. М., 1990. с.156

² А.А.Гусейнова, Р.Г.Апресян. Этика. М., 1999. с.10

³ Д.Дашдаваа, Э.Равдан. Нэр томъёоны тухай. УБ., 1990.

Түүний ингэж ялгаж үзсэнийг баримтлагчид нь нарийн ялгааг харуулан бичдэггүй нь бэрхшээлтэй.

Германы философич Ф.Ницше ёс суртахууны сэтгэл зүйн үндсийг *ressentiment* /өширхөл гэсэн франц үг/ гэсэн гэж тайлбарласан. "Сайн, муугийн ялгааг ойлгохын тулд ноёрхогч, захирагдагч ёс суртахууны хоёр хэв маяг байгааг ойлгох хэрэгтэй. Ноёрхогч ёс суртахуун төрөлхийн хүн байгалийн хүчийг номхотгодог шиг няцаагдашгүйгээр өөрийгөө нотлохоос үүсдэг, "захирагдагч ёс суртахуун үйл явуулга биш харин хариу үйлдэл бөгөөд өшөө хорслын /ressentiment/ илрэл, хүчгүй байр сууриа шахаж гаргасан үзэн ядалт, сул дорой" болно. Гэхдээ өөрөө бүтээгч буюу үнэт зүйлийг үүсгэдэг. Энэхүү *ressentiment* нь атаа, өширхөл, шунал, хардалтын урьдчилсан нөхцөл, хүсэл зоригийн хувирсан хэлбэр учраас золтой, эрхэм, эрүүлийн үндэс болно. Ноёрхогч ёс суртахуун, захирагдагч ёс суртахуун гэсэн нэр томъёог ёс суртахууны социоанализ гээд, *ressentiment*-ийг психоанализ хэмээсэн.¹ Ёс суртахуун бол үр дүн, шинж тэмдэг, баг, өвчин, эндүүрэл төдийгүй шалтгаан, хүч, хор, саад тотгор, эм дом мөн. Тэрээр ёс суртахууны ёс ойлголт хэрэглэсэн байна. Ёс суртахууны ёс нь бодгаль, автономит байдлыг даван туулахад хүнийг боловсруулдаг.² Ёсд захирагдах нь ёс суртахуунаас өөр юу ч биш. Хаана ёс байхгүй байна тэнд ёс суртахуун байхгүй. Амьдралыг хэдий чинээ ёсд захируулна төдий чинээ ёс суртахууны үнэлэмжийн хүрээнд байна.³ Ф.Ницшегийн эдгээр зохиолыг герман хэлнээс орос хэлнээ буулгахдаа нравственность, мораль гэдэг үгсээ тайлбаргүйгээр хэрэглэсэн нь учир дутагдалтай. Уг зохиолын нэр нь "*Zur genealogie der moral*" ажээ. Ф.Ницше ёс суртахуун, зан суртахуун хоёрыг ялгаатай гэж үзээгүй харин ёс суртахууны хоёр хэв маяг байгааг судалжээ.

Английн философич Э.Мур "Өөрөө өөртөө сайн", "Ямар зүйлийг өөрөө өөртөө сайн гэх вэ" гэсэн асуултанд үйлдлийн зайлшгүй нөхцөл, шалтгаан хариулна. "Сайн үр дүнд хүрэхийн тулд ямар зан байдал чухал вэ? -Зөвшөөрөгдсөн үйлдлийн бүх үр дагавар нь боломжуудаас хамгийн сайн нь байна. Боломж нь хуулийн утгатай зан байдлын шугам. Зан байдал гэж юу вэ гэдэгт хариулахын тулд сайн эсвэл муугийн асуудлыг шийдвэрлэх нь ёс зүйн судлах зүйл мөн" гэж бичжээ. Эндээс үзвэл хүний ёс суртахууны мэдрэмжийг зан байдал гээд байна.⁴ Жишээ нь "А бол сайн хүн. В бол сайхан сэтгэлтэй хүн" гэсэн хоёр бодомжийн хувьд адилхан үнэлэмж. Харин "А худлаа ярих муу гэдгийг мэдсэн ч тодорхой нөхцөлд худлаа ярихад хүрчээ" гэсэн бодомжийн предикат нь мөн л ёс суртахууны агуулгатай байна. Ийм тохиолдолд үйлдлийнхээ бурууг мэдэж байгаа нь, худлаа ярьсан нь

¹ К генеалогии морали. //Этика. Энциклопедический словарь. М.,2001. с.210

² Ф.Ницше. К генеалогии морали. М.,1997. с.306

³ Фр.Ницше. Собрание сочинений. Утренняя заря. Размышления о нравственных понятиях. /1886 г/

⁴ Дж.Э.Мур. природа моральной философии. М.,1999, с. 41

хоёулаа ёс суртахууны ухамсарт хамаарна. Энэ хоёр төлөв байдлыг Г.В.Ф.Гегель ялгаатай нэр томъёогоор илрэхийлэх гэж оролдсоныг судлаачид шүүмжлэх болжээ. Сүүлийн үед Оросын эрдэмтдийн бүтээлүүдэд мораль /нравственность/ гэж бичих болсон бөгөөд англи хэлт орнуудад moral¹ гэж бичиж байна. Зохиогч ёс, зан, суртахуун гэдэг үгсийн утга, агуулгыг тодруулах зорилгоор монгол хэлний тайлбар толиудыг олдоцын хэрээр шүүж үзлээ.

I. Монгол үгсийн язгуурын толь бичигт тэмдэглэснээр “зан” гурван янз байна. Үүнд: 1/ хүн амьтны ааль авир, зан авир, зан суртахуун, ан зан 2/ арван тохойтой тэнцэх уртын хэмжээ 3/ ялтныг занчих эрүүгийн зэвсэг гэсэн бол эрдэмтэн Шагж толь бичигтээ “гутлын зан” гэж буй хэмээн дөрөв дэх утгыг тэмдэглэжээ. “Зан” гэдэг үг нь загнах, занших, зандрах, зангарга гэх мэт үгийн үндэс болно. Мөн “Ёс” гэдэг нь нийгмийн амьдралд олны заншсан хэв суртал, ёс хийх, салах ёс гүйцэтгэх зэрэг. “Суртал” гэдэг нь -хэвшил, заншил, зан суртал, ухуулан сэнхрүүлэх ажил зэрэг² аж. Энд “зан”, “ёс” гэдэг үгс ялгаатай бөгөөд суртал нь хоёуланд нь холбогдох бололцоотой байна.

II. Хорин наймтын тайлбар тольд /Хорин нэгтийн тайлбар тольтой үндсэндээ адил/ хүн, амьтны сурч дадсаныг “зан суртал” гэнэ³. “Зан” гэж -хүний төрөлхийн чанар зөөлөн, хатуу, сэргэлэн болохыг хэлнэ. “Ёсон” гэдэг нь -төр ёс, хууль ёс, журам ёс тэргүүтэн аливаа дагаж явбаас зохих сайн мөр журмыг хэлнэ. “Суртахуун” -ертөнцийн хүний шүтлэгийг хэлнэ. Үүнд бурханы суртахуун, бичгийн суртахуун, Лао 3-ын суртахуун хэмээсэн мэт. “Суртал” -аливаа газар орны өөр өөрийн язгуурын уламжилсан зан журам хийгээд хэв журам.⁴

III. Монгол хэлний Гучин зургаатын тайлбар тольд /XVIII зууны/ “Олон цөм дууриан журамлаж суртал болсныг **зан суртал**” гэжээ. Харин ёс суртал гэж тэмдэглэгдээгүй байна. Гэхдээ “Зан” гэдэг нь -тэнгэрээс заяасан уг аж ахуй огт хувилсангүй төрөхийг хэлнэ. Зан сэтгэлгэд агуу, талбиун, зөөлөн, хатуу, дотуур гэх мэт. “Ёсон” гэдэг бол ёслолын дүрэм янзыг хэлнэ⁵ гэх зэргээр тайлбарласан. Энд “ёс”, “зан” хоёрыг ялгаатай тайлбарлажээ.

IV. Шагж авгай “ёс” гэдэг нь хэв хэмжээс, ёслол, хуулийг, бас аливаа зүг чигийг.⁶ “Зан” гэдэг нь аливаа амьтны аашлах байдал. Харин “ёс суртал” гэж үг оруулж тайлбарлаагүй. **Зан суртал** - иргэний энгийн учир дуулах, гингэнэх

¹ Encyclopedia of ethics. NY.,1992. Ed by Lawrence C.Becker and Charlotte B.Becker

² Монгол үгсийн язгуурын толь. УБ.,1966. 1671-1672 дахь тал.

³ Монгол хэлний хорин наймтын тайлбар толь. ӨМАХХ.,1994. 1871 дэх тал.

⁴ Мөн тэнд. 1407 дахь тал.

⁵ М.Сумъяабаатар. Гучин зургаатын тайлбар толь. УБ.,2005. 181 дэх тал.

⁶ Шагж. Монгол үгийн тайлбар толь. ДУУХХ.,1994. 577 дахь тал.

шүлэглэхийг, өөр өөрийн газрынх өөр хэлнэ.¹ “Суртал” - гэдэг нь өөр өөрийн хэв хуульд дадсаныг хэлнэ. “Суртахуун” - гурван сургуулийн зэргийг хэлнэ. 1/ хууль дүрэм байгуулах, 2/ олонд сэрүүл дуулгахыг 3/ заан удирдаж ардын мууг халуулан сайныг сургахыг нь хэлнэ гэж заажээ.

V. Я.Цэвэл авгай “ёс” - юмны зайлшгүй зүй тогтол, хүний даган баримтлах хэв хууль. “Зан суртал” - уламжлагдан заншиж ирсэн ёс дүрэм, хүн ард нийтээр хүлээн зөвшөөрсөн дадал зуршил. “Ёс суртахуун” гэдэг нь - хэвшиж тогтсон зан суртал. “Ёс суртахуун: зан суртахуун”² гэдэг нь энэ хоёр адил гэжээ. Онцлон буй үгсийг харь хэлнээс эх хэл рүү, эх хэлнээс харь хэл рүү яаж дүйлгэдгийг доорх хэдэн баримтаас үзэж болно.

VI. 1928 онд мэргэжлийн анхны гэмээр нэр томъёоны орос-монгол толь бичгийг орчуулахаар Улаан-Үдэд нэр томъёоны хэлтэс байгуулагдаж, нэртэй монголч эрдэмтэд оролцсоны дотор Монголоос зохиолч С.Буяннэмэх гуай томилогдож ажиллажээ. Үүнд: Этика, нравственность гэдэг хоёр үгийг хоёуланг нь - ёс суртал³ гэж орчуулсан. Магадгүй өдгөө бид өргөн хэрэглэдэг латин хэлнээс гаралтай мораль-ийг /уг нь энэ үг хэрэглэгдэж байсан цаг үе/ унаган орос үг биш гэж үзээд оруулаагүй биз.

VII. Академич Ц.Дамдинсүрэн⁴ “Орос монгол хэлний толь бичиг”-тээ нравственний - ёс суртахууны, зан суртахууны, ёс журмын гэж орчуулсан байгаа. Мөн мораль - ёс суртахуун, зан суртахуун, ёс журам⁵ гэжээ. Ц.Дамдинсүрэн, Я.Цэвэл нар ёс суртахуун, зан суртахууныг нэг утгатай гэж үзсэн нь тодорхой байна. Үүнийг нотлох нэгэн баримт бол Ц.Дамдинсүрэн “Оюун түлхүүр болбоос Монголын дотор маш түгээмэл дэлгэрсэн зохиолын нэг болмуй. Гэрээр бичиг сурах багачуудад цагаан толгой заасны дараа “Оюун түлхүүрийг” уншуулдаг байлаа. Энэ ном болвоос урьд цагт зан суртахууны сурах бичгийн чанартай хэрэглэгдэж байсан бүлгээ” хэмээн бичсэн явдал.

VIII. Charles Bawden-ий Монгол-англи толь бичигт “ёс суртахуун” -morals, ethics, morale: “зан суртахуун” -morals, morality, customs: “суртахуун” -morals, ethics: “суртал” -ideas doctrine teachings⁷ гэж тус тус дүйлгэсэн байна.

“Ёс” гэдэг үг судлаач эрдэмтдийн анхаарлыг татдаг нь хууль, цаазны уламжлалыг судлахтай ихээхэн холбоотой юм. Их Монгол Улсын үеийн “Их яаса”

¹ Мөн тэнд. 525, 880 дахь тал.

² Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966. 237, 265 дахь тал.

³ Г.Р.Ринчинэ. Русско-монгольский терминологический словарь. Верхнесудинск., 1928. с.196

⁴ Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв.Орос монгол толь. УБ., 1982. 345 дахь тал.

⁵ Мөн тэнд. 278 дахь тал

⁶ Ц.Дамдинсүрэн. Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой. УБ., 1959. 58 дахь тал.

⁷ Charles Bawden. Mongolian-english dictionary. Great Britain., 1997. p, 152, 169, 311.

хуулийн нэрийн талаар эрдэмтэд янз бүрийн санал дэвшүүлэхдээ бидний авч үзэж буй “ёс” гэдэг үгийн учрыг тайлбарлахыг оролджээ. **Яаса** буюу ёс, ёс журам гэсэн үгнээс “засаг” гэдэг нь үүдэлтэй байна. Хэл шинжлэлийн үүднээс яаса /йаса/ гэсэн үг нь о,а-гаар сэлгэж, йосун, йо-са-рун гэсэн ёс, ёс журам¹ гэсэн үг аж. Нөгөө талаар монгол, түрэг, манж хэлэнд йаса-, яаса-, заса-, даса- нь эхний гийгүүлэгч авиа л сэлгэсэн болохоос биш нэг язгуурт үг юм.² Эндээс үзвэл засаг, засах, засан тохинуулах гэж тайлбарлах нь учир дутагдалтай.

Монголын Нууц Товчоонд “ёс” хэмээх үг нь ёст хүн, анд бололцох ёс, их ёс буюу байх ёстой, зохистой хэм хэмжээ гэсэн утгаар хэрэглэгдсэн байна. Жишээ нь, 252-р зүйлд Чингис хаан Шихихутугийг “...Чи их ёсыг сэтгэжээ” гэж сайшаан соёрхдог. Лувсанданзангийн Алтан товчид³ Сүнидийн Гөлүгэдэй баатар “...Бүтэхийн урьд учирсан, Бөртгөлжин хатан чинь, Буянт хан газар нутаг ус чинь, Боорчи, Мухулай хоёр амраг нөхөр чинь, Бүрэн их ёс чинь тэнд бөлгөө...” гэх мэт. Энд дурьдагдаж буй их ёс бол “их яса” хууль эсвэл ерөөсөө ёсны дагуу байх гэсэн агуулга байж болох юм. Рашид Ад Дины бичсэнээр 1218 онд болсон их хуралдайгаар түүнийг баталж “Их ёс” хэмээн нэрийдсэн аж. Нэрт түүхч Х.Пэрлээ агсан “Нууц товчоонд үлдсэн хууль цаазын зарим зүйл” өгүүлэлдээ: “*Монголын тэр цагийн хууль цаазны дурсгалыг задлан шинжлэхэд монголчуудын хэв хууль, зан заншил, хууль зүйл гурав ялгараагүй нэг дор хутгалдан байсныг мэдэх нь чухал юм*”⁴ гэж дүгнэсэн нь “ёс”, “хууль”-ийн хэм хэмжээ, зарчмын салшгүй холбоог илтгэнэ. Эдгээр ойлголтыг нийгмийн харилцааг зохицуулах үүрэгтэйн хувьд хам утгаар ойлгож ухамсарлаж байсан нь ямар үр дүнтэй байсныг түүх гэрчилнэ. XIII зууны Монголчууд “ёс”-ыг амьдралын урт удаан туршлагын явцад бүрэлдэн, эзэн хааны зарлигаар тогдоогдон бий болж, удаан хугацаанд үйлчлэх ёстой хэмээн үзэж байсан учир урагийн урагт “ёс”-ыг дагахыг эрхэмлэдэг. Дээр өгүүлсэн баримтуудад дүн шинжилгээ хийвэл.

- “**Зан**” гэдэг үгийн утга үндсэндээ хүний төрөлхийн шинж чанар, тэнгэр бурхнаас заяасан гэдэг нь тодорхой байна. Монголчууд “А бол сэтгэл сайтай, сайхан зантай хүн байгаа юм”, “Зан сайтай айлд хүн болгон цуглана, замаг сайтай нууранд загас болгон цуглана”, “Зан муутай хүнтэй эвлэхэд хэцүү” гэх мэтээр ярьж бичдэг. Ингэхдээ “зан” гэдэг үгээр дамжуулж төрөлх авираас гадна, ёс суртахууны төлөвшлийг илэрхийлж байдаг. Зан” гэдэг нь төрөлхийн бөгөөд сэтгэл зүйн шинжтэй, “ёс” нь нийгмийн зүгээс тэрхүү зан бүхий харилцааг зохицуулах хүчин зүйл болж байна.

¹ М.Базаррагчаа. Монгол үгийн гарлыг мөшгөх нь. УБ.,1992. 210 дахь тал.

² Эзэн богд Чингисийн “Их засаг”. УБ.,1995. 8 дахь тал.

³ Лувсанданзан. Алтан товч. УБ.,1990. 145 дахь тал.

⁴ Х.Пэрлээ. Гурван өгүүлэл. УБ.,1962. 25 дахь тал.

- **“Ёс”** гэдэг үг дангаараа зүй тогтол, даган баримтлах хууль, журам, дүрэм гэсэн утгатай болох нь бүх тайлбар тольд давтагдаж байна. Доктор Х.Сэлэнгэ *“монголчууд хүний нийгмийн харилцааны байх ёстой ёс журмыг бүхэлд нь “ёс” хэмээн ойлгож ирсэн юм. Ёс-д уламжлалт зан заншил, хэв ёс /хэв хууль/, билиг сургаал, зарлиг хуулийг багтааж байсан тул ёс-д зан заншил, ёс суртахуун, эрх зүйн хэм хэмжээнүүд орж байв”* гэсэнтэй¹ санал нэгдэж байна. Энэхүү “ёс”-г илэрхийлж буй “хууль” нь төрийнхөөс гадна, жам ёс, зүй тогтол, тэнгэрлэг далдын хүч, хуучин заншлаа дагах гэх мэт агуулгатай хийгээд сайн мөрд оруулах зорилготой юм.

- **“Суртахуун”** нь хүний оюун санаа, ухамсарт гаднаас үзүүлсэн итгэл үнэмшил байна. Өөрөөр хэлбэл хүн дагах эсэх нь харьцангуй сонголттой юм.

- **“Суртал”** гэдэг үгийг нийгмийн харилцааг зохицуулдаг хүчин зүйл бөгөөд заавал дагах ёстой, дадал болсон маягтай гэж ойлгомоор байна. Дээрх тайлбаруудад үзвээс ёс суртал, зан суртал гэдэг уламжлал байжээ. Ингэхээр ёс суртахуун, зан суртахуун гэж хэрэглэхгүй байвал яасан юм бэ? гэсэн санал төрүүлж байгаа юм. Өвөр Монголын эрдэмтдийн бүтээлд голдуу ёс суртал, зан суртал гэж бичсэн байдгийг бид мэднэ. Өдгөө доктор Д.Дашжамц багш ёс суртал² гэдэг үгийг зарим үед хэрэглэсэн байдаг юм.

Харин Шагж авгайн үзсэнээр бол ёс суртахуун гэж тусад нь тайлбарлаагүй боловч салангид хоёр үгийг холбоход *“суртахуун”* гэдгийг өмнө дурьдсанаас зөвхөн 3 дахь утгаар нь/ *хүний мууг халуулж сайнд чиглүүлдэг ёслол, хэм хэмжээ* гэсэн утгатай байж болмоор юм. Магадгүй Я.Цэвэл, Ц.Дамдинсүрэн нар үүнд үндэслэсэн бизээ. Бид ёс суртахууны талаар сэтгэгчдийн хийсэн тодорхойлолтуудад илэрдэг гол санааг эндээс л харж болно. Өрнөдийн сэтгэгчид ёс суртахууныг тодорхойлсноос үзэхэд ёс суртахуунд зайлшгүй байх гурван шинж байна. **Нэгдүгээрт**, ёс суртахуун нийтлэг тал байна. **Хоёрдугаарт**, ёс суртахуун заавал ямар нэг шаардлага, хэм хэмжээ илэрхийлнэ. **Гуравдугаарт**, хүний үзэл бодол, үйл ажиллагаа өөрөө дундаж, гол ёсод захирагдахыг шаарддаг. Логик үүднээс сайныг батлахад заавал зөв, зохистой үйл хийсэн байхыг тэмдэглэнэ.

- **“Зан суртал”** нь Хорин наймтын тайлбар толиос үзэхэд төрөлхөөс тогтож төлөвшсөн байна. Үүнд **“ёс суртал”** гэж тусгайлан тайлбарлаагүй боловч салангид буй хоёр үгийг нийлүүлэн уншвал *аливаа газар оронд уламжилсан заншил, тогтоосон хууль, дүрэм* гэсэн утга илэрхийлэхээр байна. Шагж авгайнхаар тухайн орон зайд үйлчилж буй ёсыг дагах явдал юм. Гучин зургаатын тайлбар тольд “зан суртал” -нийтээр дагадаг журам. Я.Цэвэл уламжлалт ёс дүрмийг **“зан суртал”**

¹ Х.Сэлэнгэ. XIII зууны Монголын төр, эрх зүйн үзэл санаа, түүний үнэт зүйл. /диссертаци/ УБ., 2003. 64 дэх тал.

² Монголын философийн түүх /XVII-XIX/. УБ., 2001. 414 /19-р мөр/, 459 /29-р мөр/ дэх тал.

гээд, тэр нь хэвшиж тогтохыг “ёс суртахуун” гэжээ. Тэгэхээр ёс суртахуун, зан суртахуун хоёр нь яг адилхан гэж тайлбарласан байна. Эндээс зан, суртал гэдэг хоёр үгийн нийлэмж маань “ёс” гэсэн өргөн хүрээтэй ойлголтын багтаамжтай адилгалын харилцаанд орших бололцоотой гэсэн дүгнэлт хийж болно. Ингэхээр “ёс суртал” бол нэг талаас “зан суртал, суртал” гэсэн шиг сонин томъёолол үүсгэхээр байгаа юм. Зан+суртал= хүн төрөлхийн тэнгэрээс заяамал араншингаа нийгмийн зохистой харилцаанд байлгах буюу ёсны дагуу байлгах явдал гэсэн агуулгаар тайлбарлаж болно. Энэ нь ёс зүйн судлагдахуун мөн.

Хүмүүнийг зөв зан сурталтай болгохын тулд ёс-ыг арга хэрэгсэл болгоно. Жишээ нь ухамсаргүйгээ хүн ёс суртахууны хэм хэмжээгээр хязгаарладаг. Харин ёсноос гажвал буруу зан сурталтай хүн л гэж үнэлэгдэнэ. Ёс+суртал=дүрэм, журам, зан заншил, хэм хэмжээ, баримтлах сайн чиг, мөр тогтож хэвшсэн байх явдал юм. Ийм байр сууринаас хандвал дээрх хоёр үг адилхан болж таарна. Өөрөөр хэлбэл зан сурталтай байна гэдэг бол ёс сурталтай, ёс сурталтай бол зан сурталтай байна гэсэн үг. Хоёулаа бүх нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн нийгмийн бүх гишүүд дагаж мөрддөг шаардлага, хэм хэмжээ байна. Хэрэв зөвхөн зан, ёс гэсэн үгнүүдэд төвлөрөн үзвэл нэг нь сэтгэл зүйн нөгөө нь нийгмийн гэсэн ялгаатай тайлбар байна. Ялган хэрэглэнэ гэвэл бие хүний харилцаа, төлөвшлийг зан суртахуун гээд, хэсэг бүлгийн, нийгмийн төвшиний харилцаанд тавигдах хэм хэмжээг ёс суртахуун гэж болох нь тайлбар толиудаас харагдана.

Ёс суртахууны ухамсар, сэтгэл зүйн илрэл хоёр нь маш нарийн учир холбогдолтой үзэгдлүүд юм. Өөрөөр хэлбэл ёс суртахууны ухамсрыг сэтгэлээр үнэлэх, сэтгэл хөдлөл, ханамжийг ёс суртахуунлаг чанараар тайлбарлах нь нийтлэг. Энэ тухай Аристотель, Ф.Брентано, З.Фрейд нарын онолд өгүүлдэг. Германы философич Франц Брентано ёс суртахууны ухамсарт сэтгэл зүйн шинжилгээ хийгээд “Хүнд ёс суртахуунлаг чанар, үнэлэмж тодорхой сэтгэл хөдлөлийн баримтаас үүснэ”¹ гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Жишээ нь “Би хулгай хийхгүй” гэсэн бодомжийг шинжлэхэд би хулгайлмаар санагдсан ч нийгмийн ёс суртахууны хэм хэмжээнд захирагдаад болино эсвэл ерөөсөө хулгайлж болохгүйг ухамсарлана. Энд хувь хүний хүсэл ба хэрэгцээ, нийгмийн шаардлага хоёр зөрчилдөж байна. Мөн янз бүрийн этикет /ёс горим/ хүмүүсийн дотоод сэтгэл зүрхнээс илрэхгүй байж болно. Энд харилцаанд ёс суртахуун нь агуулга, этикет нь хэлбэр болжээ. Хэдийгээр ёс суртахуун, сэтгэл хоёр харилцан холбоотой ч ёс зүйн зорилго нь сайн муу, зөв буруугийн тухай судалдаг. Иймээс хулгай хийхийг хүсэх, ёс горим барихгүй байх нь ч ёс суртахууны чанар.

Манай орны судлаачдын дунд ёс зүйн нэр томъёог янз бүрээр оноож, заримдаа онолын гэмээр төөрөгдөл алдаа гаргах явдал ажиглагдаж байна. Энэ

¹ Франц Брентано. О происхождении нравственного познания. Спб., 2000. с.13

зөрчлийг даван туулахын тулд сэтгэгчдийн тайлбараас гадна, эх хэлнийхээ арвин баялаг үгийн сан луу өнгийж байх нь зүйтэй юм. Эндээс дүгнэн үзвэл: Ёс суртахуун, зан суртахуун хэмээх ойлголтуудыг адил утгаар хэрэглэснээр алдаанд хүрэхгүй. Гэхдээ эрдэм шинжилгээний тодорхой нэг бүтээлд зөвхөн аль нэг үгээ дагнан бичиж заншвал зохимжтой юм. Монголчууд ёс суртахуун, зан суртахуун биш ёс суртал, эсвэл зан суртал гэдэг уламжлалтай байжээ.

Ном зүй.

1. Базаррагчаа.М. Монгол үгийн гарлыг мөшгөх нь. УБ.,1992.
2. Г.В.Ф.Гегель. Философия права. М.,1990. /диссертаци/ УБ.,2001
3. А.А.Гусейнова, Р.Г.Апресян. Этика. М.,1999
4. Дамдинсүрэн.Ц. А.Лувсандэндэв.Орос монгол толь. УБ.,1982.
5. Дж.Э.Мур. Природа моральной философий. М.,1999
6. Золзаяа.М. Ёс зүй. УБ.,2005
7. Лувсанданзан. Алтан товч. УБ.,1990
8. Монгол үгсийн язгуурын толь. УБ.,1966
9. Монгол хэлний хорин наймтын тайлбар толь.ӨМАХХ.,1994
10. Монголын философийн түүх. УБ.,1997
11. Ф.Ницше. К генеалогии морали. М.,1997.
12. Фр.Ницше. Собрание сочинений.Утренняя заря. Размышления о нравственных понятиях.
13. Пэрлээ.П. Гурван өгүүлэл. УБ.,1962
14. Г.Р.Ринчинэ. Русско-монгольский терминологический словарь. Верхнесудинск.,1928
15. Сэлэнгэ.Х. XIII зууны Монголын төр, эрх зүйн үзэл санаа, түүний үнэт зүйл. /дисс/ УБ.,2003.
16. Сумъяабаатар.М. Гучин зургаатын тайлбар толь. УБ.,2005
17. Тунгалаг.Д. Ёс зүй. УБ.,2002
18. Цэвэл.Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.,1966.
19. Цэрэннадмид.А. Хүн ёс, хүн төрх, зан суртахуун.УБ.,2002
20. Шагж. Монгол үгийн тайлбар толь. ДУҮХХ.,1994
21. Философи эхлэн сурах бичиг. УБ.,2000.
22. Франц Brentano.О. происхождения нравственного познания. Спб.,2000
23. Фэн Ю Лань. Хятадын философийн товч түүх. УБ.,2003
24. Эзэн богд Чингисийн "Их засаг". УБ.,1995.
25. Этика энциклопедический словарь. М.,2001.
26. Oxford dictionary. OUP. 1996.
27. Charles Bawden. Mongolian-english dictionary. Great Britain.,1997